# Сайн байна уу? Камбожоос мэндчилж байна!



**Сайн байна уу! Намайг Паоло гэдэг! Харин энэ бол Марго.**





Бид Камбожид айлчилж байна. Бид дараах зүйлийг мэдэж авсан!




Камбожийн ихэнх хүүхэд эцэг эхтэйгээ хамт мотоцикл унан, сургуульдаа болон сүмдээ явдаг. Эсвэл тэд *tuk tuk* гэдэг жижигхэн мотоцикл тэргээр явж очдог.





Ерөнхийлөгч Нэлсон өнгөрсөн жил Камбожийн нийслэл Пномпеньд анхны ариун сүм баригдана гэдгийг зарласан. Ариун сүм нь тэдний шиг гэр бүлийг мөнхөд хамт лацдан холбогдоход туслах юм.



Камбожид Хүүхдийн хэсгийн олон хүүхэд сургуулийнхаа Христэд итгэдэг цорын ганц хүүхэд байх нь элбэг. Энэ нь Камбожид ихэнх хүн Буддын шашин шүтдэгтэй холбоотой. Шашин шүтлэг нь тэдэнд үнэнч, амар амгалан, ухаалаг байхыг заадаг. Энэ бол Камбож дахь Буддын алдартай хөшөө дурсгал бөгөөд дэлхийн өнцөг булан бүрээс хүмүүс энд айлчлан ирдэг.



Энэ бол камбож хэл дээрх Мормоны Ном. Камбож хэлийг кхмер (kuh-MY) гэдэг. Цагаан толгой нь дэлхийн хамгийн их, 74 үсэгтэй.



Сүмийн энэ гишүүд *sampeah* гэдэг Камбожийн уламжлалт аргаар хоорондоо мэндчилж байна. Гараа өндөрт өргөх тусам таныг тэдий чинээ их хүндэлж байгаа хэрэг юм.

Камбожийн ихэнх хоолонд *prahok* хэмээх загасны гашуун, давстай амтлагчийг хэрэглэдэг. Сүмийн гишүүд Ерөнхий чуулганы завсарлагаанаар гадасны төв дээр хамтдаа хооллохоор том тогоотой шөл хийсэн байгаа нь энэ.



Камбожоор бидэнтэй хамт аялсанд баярлалаа! Дараа дахин уулзацгаая!



## Зарим камбож найзтай минь танилцана уу!



Би Бурханыг дуулгавартай дагасан үедээ маш их аз жаргалтай байдаг.

**Синэт Б., 6 настай, Камбож, Кампонг Том**



Би номлогчдоос гэрээр хичээл авсныхаа дараа баптисм хүртсэн ба одоо маш их баяртай байгаа.

**Сина Б., 8 настай Камбож, Кампонг Том**

**Та Камбожид амьдардаг уу? Бидэнд захидал бичээрэй! Бид таныг сонсохыг хүсэж байна.**


БИЕ БИЕТЭЙГЭЭ МЭНДЭЛЖ БАЙГАА ГИШҮҮД БОЛОН МОТОЦИКЛ УНАЖ БУЙ ЭРЭГТЭЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ ЖЭЙМС ИЛИФФ ЖЭФФРИ АВАВ
ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КЭТИ МАКДИЙ    ХООЛ ХИЙЖ БАЙГАА ГИШҮҮДИЙН ГЭРЭЛ ЗУРГИЙГ СЭЛИА ЖЭФФРИ АВАВ